

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2023 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн
А/133 дугаар тушаалын хавсралт

САНГИЙН ЯАМНЫ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ
ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Журам, дүрэм, зааврын агуулга	Хугацаа	Биелэлт
Нийгмийн даатгалын сангуудын захиран зарцуулалтад анхаарах асуудлаар			
1.8.	Нийгмийн даатгалын шимтгэлийн 121 хоногоос дээш насжилттай хуримтлагдсан авлагыг бууруулах талаар хийх ажлыг эрчимжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаанд тавих шат шатны хяналтыг сайжруулахад анхаарч ажиллах;	Хагас, бүтэн жил	2023 оны жилийн эцсээр нийт 2980.7 сая төгрөгийн авлагатай гарсан. Оны эхний авлагаас 95.0% буюу 2823.9 сая төгрөгийг барагдуулсан байна. Үүнээс үлдэгдэл 156.8 сая төгрөг үлдээд байна. Урсгал авлага 850.1 сая төгрөгийн авлагатай гарахаар байна. Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн албанд нийт 12 аж ахуй нэгжийн 118.6 сая төгрөгийн найдваргүй авлагыг шилжүүлж, 112.1 сая төгрөгийг барагдуулаад байна. Нийгмийн даатгалын шимтгэлээ хуулийн хугацаанд төлөөгүй 174 аж ахуй нэгж байгууллагын 1158.5 сая төгрөгт дансны хаалт хийж, 1100,1 сая төгрөгийг татан авсан, Хэнтий аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 15 аж ахуй нэгжийн 97.6 сая төгрөгийн авлага барагдуулах нэхэмжлэл гарган нэхэмжлэлийн шаардлагыг хангуулаад байна. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогод эзлэх хувь 1.4 байна
1.10.	Нийгмийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь заалтыг хэрэгжүүлэн хөрөнгийн үр өгөөж, ашиглалтыг сайжруулах, сангийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;	Бүтэн жил	Аймгийн Улсын бүртгэлийн газар, Татварын газартай хамтран шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж байгууллагын судалгаанд үндэслэн албан журмын даатгуулагчийн хамралтыг нэмэгдүүлэх чиглэлийг сумдын байцаагчдад өгсөн. Үйл ажиллагаа явуулдаг боловч нийгмийн даатгалд хамрагдаагүй 12 ажил олгогчийг илрүүлж, тайлан тооцоог хийсэн. 2024 оны байдлаар нийгмийн даатгалд шинээр 89 ажил олгогчийг нийгмийн даатгалд шинээр хамруулсан. Мөн албан журмын даатгуулагчийн тоог 286 даатгуулагчаар нэмэгдүүлэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан. Нийт 4969 иргэн сайн дурын даатгал хамрагдсан байна. Үүнээс 835 даатгуулагч шинээр хамрагдсан. Сайн дурын даатгалд хамрагдсан малчдын тоо нийт 2286 бөгөөд шинээр 486 малчин хамрагдсан. 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн даатгалд нийт 876 даатгуулагч хамрагдсанаас шинээр 63 даатгуулагч хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхийг даатгалд шинээр 46 даатгуулагч хамрагдаад байна. Малчдыг сайн дурын даатгалд хамруулах ажлыг сумын Тамгын газартай хамтран багуудад сургалт, сурталчилгаа хийж хамрагдалтыг нэмэгдүүлэн ажиллаж байна. Мэргэжил арга зүйн зөвлөгөөг сумдын байцаагчдад өгч, татварын газар улсын

			бүртгэлийн хэлтэстэй хамтран ажиллаж үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчийн мэдээллийг тулгаж шинээр нийгмийн даатгалд хамрагдвал зохих аж ахуй нэгж байгууллагын судалгааг гарган хамруулах ажлыг зохион байгуулж байна.
1.11.	Тэтгэврийн хувийн хэргийн бүрдлийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах;	Хагас, бүтэн жил	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогыг хагас, бүтэн жилээр сумын Засаг даргын тамгын газартай хамтран ажлын хэсэг байгуулж, тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэргийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалтыг нэгдсэн мэдээллийн баазтай тулган шалгаж хэвшээд байна. Хэнтий аймгийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 22 сумын 13442 тэтгэвэр авагчийн хувийн хэрэг бүрэн тоологдсон. Тооллогын явцад тэтгэвэр авагчдын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй, нэгдсэн мэдээллийн сангийн масайвын дарааллын дагуу хадгалагдаагүй сумдын хувийн хэрэг, материалыг цэгцлэх, хадгалалт, хавтасны бүрэн бүтэн байдлыг сайжруулах үүрэг өгч ажилласан. Мөн Бэрх, Дархан, Хэрлэн сумын тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийн хавтсыг бүрэн шинэчилсэн.
1.12.	Архивын лавлагаа, шүүхийн шийдвэрийг хуурамчаар гаргуулан тэтгэвэр тогтоолгосноос нийгмийн даатгалын санд их хэмжээний хохирол учруулах магадлалтай байх тул холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох тогтолцоог бий болгох;	Хагас, бүтэн жил	Хэнтий аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүх, аймгийн архивын тасагтай хамтран ажиллаж мэдээлэл солилцох уулзалтыг 2024 оны эхний улиралд зохион байгуулан санал солилцож даатгуулагчдын цалин хөлсний тодорхойлолт, ажилд орсон гарсан тушаалын хуулбар, лавлагаа, малын а дансны лавлагаа гаргах, шүүхийн шийдвэр гаргахад анхаарах асуудлыг харилцан тохиролцсон. Мөн өмнө гаргасан шүүхийн шийдвэр, архивын лавлагаанд гарсан зөрчлийг дахин давтахгүй байхыг тал дээр хамтран ажиллаж тус хэлтсээс зөвлөмжийн хуудсыг ойлгомжтой бөглөж ямар тохиолдолд лавлагаа авах, шүүхийн шийдвэр гаргуулах шаардлагатай зэргийг тодорхой бичиж иргэд, даатгуулагчдад чирэгдэлгүй шуурхай үйлчлэх нөхцөл боломжоор ханган хамтран ажиллахаар болсон. Дээрх 2 байгууллагатай хамтран ажилласнаар архивын лавлагаа, шүүхийн шийдвэр үнэн зөв гаргах, хуурамчаар үйлдэх зөрчил гарахгүй байх нөхцөл боломж бүрдэж байна гэж үзэж байна. Аймгийн архивын газартай, сумдын байцаагчид бид хамтран ажиллах хүрээндээ А данс авах шаардлагатай иргэдийн ажилласан жилийг тооцон үзэж шаардлагатай малчин жилийн болзол хангасан иргэдэд зөвлөмжийн хуудас бичиж түүний дагуу архивын лавлагаа гаргаж байгаа нь ажлыг нь хөнгөвчилж байна.
1.13.	Тэтгэмж авагчдын цалин хөлсний дунджийг зөв тооцоолох, ажилгүйдлийн тэтгэмжийг тогтоохдоо даатгуулагчийн сүүлийн бүтэн ажилласан гурван сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос тооцож, хувийн хэрэгт тогтоосон, баталсан, зөвшөөрсөн,	Хагас, бүтэн жил	Засгийн газрын 2023.12.13 438 дугаар тогтоол “Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт тэтгэмж олгох журмын” дагуу ажилгүйдлийн тэтгэмжийг цаасаар болон цахимаар хүлээн авч тэтгэмж олгох даатгуулагчийн жагсаалтыг хяналт шалгалтын байцаагчаар хянуулан харьяалах нэгж хэлтэс, газрын даргаар баталгаажуулан хуваарийн дагуу тухай бүр тэтгэмж олгох жагсаалтыг сангийн нягтлан бодогчид хүргүүлж олголт хийж даатгуулагчид олгосон тэтгэмжийг ажилгүйдлийн хувийн хэрэгт тэмдэглэгээ хийж байна. Мөн

	хянасан албан хаагчдын гарын үсгийн бүрдлийг бүрэн хангуулах;		тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон 4 даатгуулагчийн тэтгэмжийг зогсоож тухайн даатгуулагчтай тооцоо нийлсэн. Ажилгүйдлийн даатгалын сангаас 573 даатгуулагчид 1639,2 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.
1.14.	Ажилгүйдлийн тэтгэмж авагчийн тэтгэмж авах хугацаа дуусгавар болсон тохиолдолд тэтгэмжийн олголтыг зогсоон тооцоог үнэн зөв хийж, хувийн хэргийг хааж, архивт шилжүүлэх;	Хагас, бүтэн жил	Ажилгүйдлийн тэтгэмж авагчийн тэтгэмж авах хугацаа дуусгавар болсон мөн ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон 181 тэтгэмж авагчийн тэтгэмжийн олголтыг зогсоон тооцоог хааж хувийн хэргийг архивын нэгж бүрдүүлэн архивд шилжүүлсэн.
1.15.	Шүүхийн шийдвэрээр ажилдаа эгүүлэн томилогдон, ажилгүй байх хугацааныхаа цалинг нөхөн авсан иргэдийн мэдээллийг холбогдох байгууллагаас авч тухайн даатгуулагчийн ажилгүй байх хугацаанд авсан ажилгүйдлийн тэтгэмжийг санд буцаан төлүүлэх арга хэмжээ авах;	Хагас, бүтэн жил	Тайлант хугацаанд шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн орсон, ажилгүй байх хугацааны цалинг эргүүлэн авсан тохиолдол гараагүй бөгөөд үүнтэй холбоотой ажилгүйдлийн тэтгэмжийг илүү олгосон зөрчил гараагүй болно.
1.25.	2006 оноос өмнөх ажилласан жилийн лавлагааг цахим мэдээллийн санд оруулж, хөгжүүлэлт хийх;	Хагас, бүтэн жил	Иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт болон нөхөн даатгалын лавлагааны хүсэлтийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс able программ, албаны мэйлээр хүлээн авч хариуг ажлын 3 хоногийн дотор гарган өгч хэвшээд байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус газарт 562 иргэнээс лавлагааны хүсэлт ирж, 533 иргэн, байгууллагад нийгмийн даатгалын төрөлжсөн архивын лавлагааг олгосон байна. 2006 оноос өмнөх ажилласан жилийн лавлагааг цахим мэдээллийн санд оруулж, хөгжүүлэлт хийх ажлыг эхлүүлэн энэ онд Бэрх-Уул ХХК, Бор-Өндөр сумын Уулын баяжуулах үйлдвэрийн шимтгэл төлөлтийн мэдээллийг цахим мэдээллийн санд оруулах хүсэлтийг нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн. Мөн 5 иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2000-2006 оны мэдээлэл ороогүй байгаа хүсэлтийг хүлээн авч цаасан тайланг шүүн лавлагааг олгож шимтгэл төлөлтийн мэдээллийг цахим санд оруулж ажилласан.
1.27.	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цаасаар хүлээж авахгүйгээр цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах;	Хагас, бүтэн жил	Хэнтий аймгийн хэмжээнд ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Монпасс ХХК, Нью конпасс ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж 100 хувь цахимаар авч ажиллаж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан хүлээж авахдаа шинээр ажилд орсон даатгуулагчийн мэдээллийг улсын бүртгэлийн “regweb” программтай тулган баталгаажуулан бүртгэж байгаа тул регистрийн дугаар, овог, нэр буруу орох эрсдэл гарахгүй байна. Тайлант хугацаанд 982 ажил олгогч байгууллагын шимтгэл төлөлтийн тайланг 100 хувь хүлээн авч ажилласан.
1.28.	Ажилтан, албан хаагчдын хагас жил, жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гүйцэтгэлийн	Хагас, бүтэн жил	Ажилтан албан хаагчдын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 301 тогтоолын хавсралт “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн

	төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ тус бүрээр үнэлж, хариуцлага хүлээлгэх, урамшууллыг тооцох;		төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журам"-г баримтлан газрын даргын тушаалаар үнэлгээний баг байгуулан байцаагч, ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг арга хэмжээ тус бүрээр үнэлж дүгнэсэн. 2024 онд нийт албан хаагчдаас маш сайн үнэлгээ 13, хэвийн 16, хангалтгүй 2 үнэлэгдсэн ба маш сайн буюу хэвийн үнэлэгдсэн албан хаагчдад батлагдсан цалин санд багтаан үндсэн цалингийн 20-50 хүртэл хувиар урамшуулал олгосон.
1.29.	Сумдын байцаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тухайн сумын Засаг даргын Тамгын газрын даргаар баталгаажуулсан тохиолдолд ажлын үр дүнг үнэлэх;	Хагас, бүтэн жил	2024 онд сумдын 20 байцаагчтай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан сумын Засаг даргын Тамгын газрын даргатай хамтран баталж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээний хуудсыг сумын Засаг даргын Тамгын газрын даргаар баталгаажуулан авч үнэлгээний баг өгсөн үнэлгээг нягтлан баталгаажуулж ажилласан.
1.30.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны "Журам батлах тухай" 24 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын төлөөлөгч ажиллуулах журам"-д заасны дагуу ажил үүргийг гүйцэтгүүлэх, Нийгмийн даатгалын орон тооны бус төлөөлөгчийн хэрэгжүүлсэн ажлын тайланд хяналт тавьж ажиллах;	Хагас, бүтэн жил	Манай газар нь 2024 онд даатгалын төлөөлөгч ажиллуулаагүй болно.
1.31.	Ажилтнуудын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, албан хаагчдыг мэргэшүүлэх талаар шат дараатай арга хэмжээ авах;	Хагас, бүтэн жил	Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хэнтий аймгийн нийгмийн даатгалын газар, "Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 вебинар" сургалтад давхардсан тоогоор 840 албан хаагч хамруулсан. Мөн 2024.01.12 ны өдөр НДЕГ-аас зохион байгуулсан "Цахим мэдээллийн цаг"-ийг "Хүн амын орлогын албан татварын тухай хууль, тайлан гаргахад анхаарах асуудал"-ын талаар сургалтад газрын 26 алба хаагч хамрагдсан. 2024.01.19 -ний өдөр "ХАСХОМ мэдүүлэх нь" сэдэвт сургалтад газрын 26 алба хаагчид бүрэн хамрагдсан. 2024.01.22 - ны өдөр Sicos системийн талаарх сургалтад газрын 26 алба хаагчид бүрэн хамрагдсан. 2024.01.29 -ний өдөр Хэнтий аймгийн хяналтын прокурор, хууль цаазын дэд зөвлөх Н.Амгалан "Зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулахад анхаарах асуудлууд" сэдвээр газрын албан хаагчдад сургалт, мэдээлэл хүргэлээ. Тус сургалтад газрын 10 албан хаагч болон сумдаас онлайнгаар 18 байцаагч оролцсон. 2024.02.20 -ны өдөр "Ажил олгогчийн тайлангийн систем" -ийн танилцуулга сургалтад цахимаар ОШТ-ийн дарга, Орлого шимтгэлийн байцаагч, ХШТ-ийн дарга, Хяналт шалгалтын байцаагч, Үйл ажиллагааны нягтлан, Мэдээллийн технологийн мэргэжилтэн нар хамрагдсан. ХНХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга сургалтад газрын 25 алба хаагч

			<p>хамрагдсан.</p> <p>2024.04.08 "Хөдөлмөрийн аюулгүй байдал- эрүүл ахуйн сарын аян- 2024" хүрээнд хийгдэж буй цахим сургалтад тус газрын 27 алба хаагч хамрагдсан.</p> <p>2024.04.15 "Цахимд хэвшье "DIGITAL FIRST - 01" Сургалтад тус газрын дарга Н.Нямхатан, Мэдээлэл технологийн мэргэжилтэн Б.Баярсайхан нар хамрагдсан.</p> <p>Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 2024.10.24-25-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 36 албан хаагч хамрагдсан байна.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024.10.24-ны өдрийн 05/2196 албан тоотын дагуу улсын байцаагчийн шалгалтад хамрагдах байцаагчдын сургалтыг 2024.10.28-2024.11.06-ны өдрүүдэд зохион байгуулсанд нийт 10 байцаагч хамрууллаа.</p> <p>"Гамшгийн үед авах арга хэмжээ" сургалтыг 2024.11.01-ны өдөр НДЕГ-с цахимаар нийт 35 албан хаагч хамрагдсан.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, манлайллыг дэмжих, ёс зүй төрийн албыг бэхжүүлэх сургалтыг 2024.11.07-ны өдөр 25 албан хаагчид хамруулсан.</p> <p>Гамшгаас урьдчилан сэргийлэх нь сургалтыг Аймгийн Онцгой байдлын газраас төвийн нийт 13 албан хаагч, Сумын 16 албан хаагчдыг ZOOM- хамруулсан байна.</p>
1.32.	Дотоод хяналтын үр нөлөөг улам сайжруулах талаар ажил зохион байгуулж ажиллах;	Хагас, бүтэн жил	<p>Тайлант хугацаанд дотоодын хяналт, шалгалтын төлбөр зөрчлийн 2024 оны эхний үлдэгдэл 38.1 сая төгрөг байсан ба шинээр шалгаж илрүүлсэн 7.2 сая төгрөгийн төлбөр зөрчил нэмэгдэж, нийт 45.4 сая төгрөг болсон. Үүнээс 18.4 сая төгрөгийг барагдуулж, нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн байна.</p> <p>Тус газрын 2024 онд хийх хяналт, шалгалтын төлөвлөгөөг батлан, нийгмийн даатгалын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар чиглэлийн дагуу дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор баталсан "Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө"-ний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13-07/08 дугаартай "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтын хэрэгжилтийг шалгасан. Шалгалтаар 107.3 сая төгрөгийн улсын байцаагчийн акт үйлдэн, 74.1 сая төгрөгийг барагдуулан, 33.2 сая төгрөгийн төлбөр зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дархан, Баянмөнх сумын төсөвт байгууллагуудын 2022-2023 оны санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримтад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Шалгалтаар давхардсан тоогоор</p>

		<p>93 даатгуулагчийн 50.4 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод 11.9 сая төгрөгийн шимтгэл ногдуулан хугацаа хэтрүүлсэн хоногт 5.9 сая төгрөгийн алданги тооцон улсын байцаагчийн акт үйлдэн нийт 17.8 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн 10 байгууллагын албан тоот, хүсэлтийн дагуу улсын байцаагчийн акт үйлдэн нийт 0.87 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлснийг төлүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>Дотоодын хяналт шалгалтын явцад илэрсэн өндөр насны 2 тэтгэвэр авагчийн 7.2 сая төгрөгийн тэтгэвэр илүү олгосон зөрчил илэрч, нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2018- 2023 онд шинээр болон хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авсан нийт 2420 иргэний тэтгэвэр тогтоолгосон баримтын үндэслэлийг, мөн Давхардсан тоогоор нийт 76606 тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл, анхан шатны баримтад тулгуурлан шалгасан. Шалгалтаар нэр бүхий 32 иргэнд тэтгэврийн олголтыг илүү, дутуу тооцож олгосон зөрчил илэрч, 10 тэтгэвэр авагч нарт илүү тооцож олгосон нийт 48821617 төгрөгийг нөхөн төлүүлэхээр, 22 тэтгэвэр авагч нарт дутуу тооцож олгосон 31524498 төгрөгийг нэг удаа нөхөн олгохоор, баримтын бүрдэл дутуу 11 тэтгэвэр авагчийн дутуу бүрдүүлсэн барим бичгийг нөхөн бүрдүүлэхээр, хуурамч баримт бичиг бүрдүүлэн хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон 1 тэтгэвэр авагчийн олголтыг түдгэлзүүлэн зогсоож шийдвэрлэсэн. Мөн давхардсан тоогоор нийт 8569 даатгуулагчид олгосон тэтгэмжийн тогтоолт, олголтын үндэслэлийг 2018-2023 оныг хамруулан шалгахад 9 даатгуулагчид илүү олгосон ажилгүйдлийн тэтгэмж 7861329 төгрөг, 21 даатгуулагчид илүү олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 871388 төгрөг, 3 иргэнд үндэслэлгүйгээр олгосон тэтгэмж 3000000 төгрөгийг тус тус нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хооронд Хамтран ажиллах санамж бичгийн дагуу Хэнтий аймгийн Дадал сумын хилийн цэргийн 0287 дугаар ангитай байгуулсан санамж бичгийн хүрээнд 2021-2024 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг холбогдох баримтад үндэслэн шалгасан. Шалгалтаар улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагчийн ажилгүй байгаа эхнэр, нөхөр, жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй байгаа цэргийн алба хаагч эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг ирүүлсэн жагсаалтын дагуу шалган үзэхэд 20 даатгуулагчийн төрлийг буруу сонгон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тусгасан зөрчил, 2024 оны 07 дугаар сарын 15-ний өдрийн 03/105 тоот албан бичгийн хавсралтын дагуу улсын хил дээр алба хааж байгаа цэргийн алба хаасны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосны дараа цэргийн цолтой ажилласан, 2 цэргийн алба хаагчийг энгийнээр бүртгэсэн зэрэг зөрчил илэрсэн. Тус санамж бичгийн хүрээнд Хилийн цэргийн 0287 дугаар</p>
--	--	--

			ангийн 20 даатгуулагчтай холбоотой 2814565 төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлж, 2 даатгуулагчид холбоотой 1901416 төгрөгийн илүү төлсөн шимтгэлийг дараа сард суутган тооцохоор, илэрсэн зөрчлийг залруулах арга хэмжээ авч ажилласан.
1.34.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөж ажиллах, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийдэг зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч ажиллах;	Тухай бүр	УИХ-н 47-р тогтоолыг хэрэгжүүлэн зардал тус бүрийг хэтрүүлэлгүй зарцуулж, батлагдсан төсөвтөө багтаан ажил үйлчилгээг явуулсан. 2024 онд 45 орон тоотой ажиллахаас 39 орон тоотой ажиллаж иргэд даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэн ажилласан. 2024 оны төрийн албаны зөвлөлийн 411-р тогтоолын дагуу тэтгэвэрт гарсан албан хаагч болон төрийн албаны шалгалт өгөөгүй / гэрээгээр ажиллаж байсан/ албан хаагчдын сул оронд тоонд ойролцоо сумдын болон газрын албан хаагчдыг давхар хавсруулан гүйцэтгүүлж ажилласан байна.
1.37.	Харилцагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлбөрийн баримт аваагүй зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;	Тухай бүр	2023.01.02-ны өдрөөс эхлэн FINANCE Санхүүгийн гүйлгээний программ ашиглаж эхэлсэнтэй холбогдуулан харилцагч байгууллагаас EBARIMT.mn сайтаар нэхэмжлэх шивүүлж мөн холбогдох баримтыг сканердаж хавсаргаж гүйлгээг илгээж байна. Үүний дараа бар кодтой баримтыг хэвлэн бүрдүүлэн ажиллаж байна. Цалин хөлсийг төрийн албаны цалингийн нэгдсэн систем /Payroll.gov.mn/ болон санхүүгийн программд тулгуурлан сард 2 удаа бодож бар кодтой төлбөрийн хүсэлт болон цалингийн хүснэгтийг хэвлэн авч анхан шатны баримтыг бүрдүүлэн ажиллаж байна.
1.38.	Санхүүгийн хяналт шалгалтын явцад өгсөн зөвлөмж, мөн дотоодын хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж зөвлөмжийн биелэлтийг тооцож ажиллах, нийгмийн даатгалын санд учруулсан хохирлыг гэм буруутай этгээдүүдээр төлүүлэх, зөрчлийг гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцож, зөрчлийг таслан зогсоох арга хэмжээг авч ажиллах;	Тухай бүр	а/ Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг барагдуулах ажлын хүрээнд сум тус болгонд өглөг авлагын тайланг хүргүүлэн барагдуулж ажилласан. Бусад өглөг нь ихэвчлэн сангийн данс хооронд андуурч хийсэн гүйлгээ байсан. Эрүүл мэндийн шимтгэлийн орлогыг ерөнхий орлогын дансанд тушаах гэх мэт өглөг үүссэнийг залруулан ажилласан. Оны эхэнд бусад авлага 54,3 сая, өглөг 11,5 сая төгрөг байсныг барагдуулж тайлант хугацаанд 10 хувиар буурсан. б) Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа оны эхэнд өглөг, авлагагүй гарсан бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар өглөг авлага үүсгээгүй ажилласан болно.

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР